

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Хаяг:

Сүхбаатар дүүрэг 6-р хороо, Их
сургуулийн гудамж, #АВ центрийн
11 давхарт 1101 тоот

Цахим хаяг:

members@amnesty.mn


Цахим хуудас:

www.amnesty.mn

Утас:

70004705, 70004706, 70004708

Бидний үйл ажиллагаа хүрсэн газрууд



ГАРЧИГ

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА

2

«ЗОРИГТОН» ХҮНИЙ ЭРХ
ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ
КАМПАНИТ АЖИЛ

4

ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ
КАМПАНИТ АЖИЛ

6

7

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ
КАМПАНИТ АЖИЛЭРСДЭЛД БҮЙ ХУВЬ ХҮМҮҮС
КАМПАНИТ АЖИЛ

8

9

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН
ЭРХ - ОРОН БАЙРТАЙ БАЙХ
ЭРХИЙН ТӨЛӨӨ КАМПАНИТ АЖИЛХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ
КАМПАНИТ АЖИЛ

14

19

ЭМНЕСТИГИЙН ЗАЛУУЧУУД:
2020 ОНД

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

22


23

2020 ОНД ХЭВЛЭСЭН НОМ,
ТОВХИМОЛ

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нобелийн шагналт Олон Улсын Хүний Эрхийн Эмнести Интернэшнл байгууллага нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад баримт бичгүүдэд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхийн төлөө үйл ажиллагаа өрнүүлдэг дэлхий нийтийн томоохон хөдөлгөөн бөгөөд Монгол Улсад 1994 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Өнгөрсөн 25 жилийн хугацаанд бид кампанит ажлуудаар дамжуулан Монгол Улсын иргэдэд тэдний иргэний, улс төрийн, эдийн засгийн болон нийгэм соёлын эрхийг нь таниулах үйл ажиллагааг сургалт, олон нийтийн үйл ажиллагааны хэлбэрүүдээр зохион байгуулсаар ирсэн. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 7000 гаруй гишүүн дэмжигчидтэй, нийслэл болон орон нутгийн, мэргэжил, сонирхлын зэрэг 25 бүлэгтэйгээр ажиллаж байна.

Монголын Эмнести Интернэшнл байгууллагын дотоод бүтцийн хувьд Удирдах зөвлөл, Гүйцэтгэх товчоо, Хяналтын зөвлөл гэсэн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг ба бодлого, үйл ажиллагааны чиглэлийг 2 жил тутамд болдог Ерөнхий чуулганаар тодорхойлж, бүх гишүүдээс байгууллагыг төлөөлөн Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийг сонгодог. Үйл ажиллагааны бодлого, чиглэлийн хүрээнд Удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, өдөр тутмын ажил үүргийг Гүйцэтгэх товчоо гүйцэтгэдэг ба ажлын үр дүн, шийдвэрийн хэрэгжилт зэргийг Хяналтын зөвлөл хянан ажилладаг



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

УДИРДАХ ЗӨВЛӨЛ



С.Ганчимэг
Удирдах зөвлөлийн дарга



С.Очирбал
Удирдах зөвлөлийн дэд дарга



А.Отгончимэг
Санхүү хариуцсан гишүүн



Б.Энхтуяа
Компанит ажил хариуцсан гишүүн



М.Батбаатар
Судалгаа хариуцсан гишүүн



Я.Мөнхчимэг
Компанит ажил хариуцсан гишүүн



З.Балдорж
Залуучууд хариуцсан гишүүн



Т.Жанерке
Хэвлэл мэдээлэл хариуцсан гишүүн



Б.Болдсүрэн
Хүний эрхийн боловсрол хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



С.Очирбат
Хяналтын зөвлөлийн дарга



Б.Наранбаатар
Хяналтын зөвлөлийн гишүүн



Г.Сүхбат
Хяналтын зөвлөлийн гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО



Б.Алтантуяа
Гүйцэтгэх захирал



Г.Амарзаяа
Компанит ажил хариуцсан зохицуулагч



П.Мөнхжаргал
Компанит ажил хариуцсан зохицуулагч



Т.Ариунаа
Санхүүгийн ажилтан



Т.Болорсүвд
Өсөлт, хөгжил хариуцсан зохицуулагч



Я.Цэцэнзаяа
Залуучууд, цахим хэвлэл мэдээлэл хариуцсан зохицуулагч
2018 оны 09 сараас



«ЗОРИГТОН» ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ КАМПАНИТ АЖИЛ



Монгол улсад хүний эрх хамгаалагчийг хамгаалах, шударга ёсны төлөө дуугарч буй хүн бүр айдасгүй, аюулгүй орчинд үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлдэг байх хууль эрх зүйн орчныг бий болгохыг зорьж, хүний эрхийн төрийн бус байгууллагууд, Хүний эрхийн үндэсний комисс, хуульч, судлаачидтай хамтран Ажлын хэсэгт ажиллаж, төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, хууль тогтоогч нартай нөлөөллийн уулзалтууд зохион байгууллаа.

Олон нийтэд хүний эрх хамгаалагчдыг таниулах, ялангуяа Монгол улс дахь байгаль орчин, уугуул иргэд, охид эмэгтэйчүүд, бэлгийн цөөнхийн эрх болон бусад хүний эрхийн чиглэлээр ажиллаж байгаа хүний эрх хамгаалагчдыг таниулахаар Оюу толгой хяналт ТББ-тай хамтран сэтгүүлч нийтлэлч нарын дунд хөрөг найруулал бичих уралдааныг 2020 оны 2-15-наас 5-р сарын 15-ныг хүртэл

зарлан явууллаа. Тус уралдаанд радио, сонин, вэб сайтуудын нийт 19 сэтгүүлч, нийтлэлчид 21 бүтээлээр оролцжээ. Уралдаанд оролцсон сэтгүүлчид хүний эрхийн боловсрол, шаардлагатай орон байраар хангагдах, охид эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шударга ёс, байгаль орчин, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн төлөө чин сэтгэл, ур чадвараа дайчлан тэмцэж байгаа хүний эрхийн идэвхтнүүдийг сонгож хөрөг найрууллаа бичсэн байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр Эмэгтэй хүний эрх хамгаалагчийн үйл хэргийг таниулах сошиал идэвхжил өрнүүлж, вэб сайт, фээсбүүкээр гишүүд, дэмжигчид, олон нийтэд түгээж Иран, Эквадор, Гондурас, Никарагуа, Саудын Арабт эрх нь зөрчигдсөн эмэгтэй хүний эрх хамгаалагчдыг хамгаалах уриалгад гишүүд дэмжигчид цахимаар нэгдлээ.

Эмнести Интернэшнлийн Зоригтон кампанит ажлын хүрээнд бид 2018 оноос эхлэн дэлхий дахины олон хэл дээрх нэвтэрхий толь болох Википедиад хүний эрх хамгаалагч, идэвхтэн, тэмцэгч нарын түүх намтрыг байршуулах ажлыг үргэлжүүлж байна.

Орон нутагт хүний эрх хамгаалагчдыг таниулах, иргэний нийгмийг чадавхжуулах чиглэлээр Монголын Эмэгтэйчүүдийн Сантай хамтран ажиллаж, 2020 оны 4-р сарын 13-15-ны хооронд Дорнод аймгийн иргэний нийгмийн 27, төрийн байгууллагын 25, идэвхтэн залуучууд 28 нийт 80 хүнд цахим сургалт зохион байгууллаа. Хүний эрхийг хамгаалах





эрхийн талаар ойлголт өгөх, хүний эрх хамгаалагч гэж хэн болох, тэднийг хамгаалах ямар механизм байдаг, учирч болох эрсдэлээ хэрхэн үнэлэх болон сорил бэрхшээлээс урьдчилан сэргийлэх чадвар олгож, орон нутгийн идэвхтэнүүд, залуу манлайлагчдын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд уг сургалтын зорилго оршлоо.

2020 оны 5-р сарын 11-нд Гадаад харилцааны сайд, УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-ын дарга Г.Занданшатар өргөн барих үйл ажиллагаанд ТББ-ын Форумыг төлөөлөн Монголын Эмнести Интернэшнлийн Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, Оюу толгойн хяналт ТББ-ын Тэргүүн Д.Сүхгэрэл нар оролцлоо.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг хэлэлцэх, хүний эрх, хүмүүнлэг, боловсрол, соёл гээд олон чиглэлийн ашгийн бус байгууллагуудын ажиллах ээлтэй орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шинээр ТББ-ын тухай хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулах, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох чиглэлээр бусад ТББ-ын төлөөлөлүүдтэй хамтран ажиллалаа.



Ковид 19 цар тахлын улмаас олон нийтийн арга хэмжээг хориглож тул “Хүний эрх хамгаалагч залуучууд” зуны сургалтыг 6-р сарын 15-17-ны хооронд гурван өдөр цахимаар зохион байгууллаа. Тус сургалтад 23 залуучууд хамрагдсаны 30 орчим хувь нь орон нутгаас оролцсон

нь холын зайнаас ч гэсэн суралцах сонирхолтой залуучуудыг хамруулж чадсанаараа цахим сургалтын нэг давуу тал оршиж байлаа.

Туркийн 11 хүний эрх хамгаалагчдын шүүх хурлын өмнө тэднийг цагаатгахыг уриалсан онлайн үйл ажиллагаанд оюутан залуучууд үйл ажиллагаа өрнүүлж, сошиал идэвхжил өрнүүлж, уриалга гарган, Монголд улсад суугаа Туркийн элчин сайдад хүний эрхийг хамгаалсныхаа төлөө хоригдож болзошгүй байгаа Туркийн Эмнести Интернэшнлийн дарга, захирал бусад гишүүдийг оролцуулсан 11 хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалахыг уриалсан албан захидал хүргүүлээ.

Хүний эрх хамгаалагчдын эрх зүйн орчин бүрдүүлэхэд нөлөөлөх чиглэлээр ТББ-ууд, ХЭҮК-той хамтран УИХ-ын гишүүдэд хуулийн зорилго, хэрэгцээ шаардлага, хүний эрх хамгаалагчийн талаарх Загвар хуулийг таниулах лобби үйл ажиллагаа явуулж, охид, эмэгтэйчүүдийн эрх, уугуул малчдын эрх, хүний эрхийн боловсрол, байгаль орчин гээд хүний эрх, эрх чөлөөний төлөө тэмцэгчдийн намтар түүх, үйл хэргийн талаарх хөрөг найрууллыг вэб сайтаараа дамжуулан олон нийтэд танилцууллаа.

ХЭХ-ийн хуулийн төслийг хэлэлцэх асуудлыг УИХ-аар дэмжсэн нь хүний эрх, эрх чөлөөний төлөө тэмцэгчдэд хууль эрх зүйн ээлтэй орчин бүрдэх боломжийг олгосон байна.

Хөрөг найрууллын уралдаанд ирсэн бүтээлүүд, бусад хүний эрх хамгаалагчдын талаарх мэдээ мэдээллийг сошиалаар давхардсан тоогоор 200 000 гаруй хүнд хүрлээ.



ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ КАМПАНИТ АЖИЛ

Ковид 19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосон хэдий ч Монголын Эмнести Интернэшнлийн оюутны бүлгийн гишүүд Энтимема клубын гишүүдэд Жинхэнэ гэмт хэрэг киногоор цахим хэлэлцүүлэг өрнүүлсэн нь шинэлэг байлаа.


Эмнести Интернэшнлээс 4-р сарын 21-нд Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2019 судалгааг дэлхий дахинаа танилцуулж, судалгааны талаарх хэвлэлийн мэдээг Ийгл, MNC, TV25 зэрэг телевиз, <https://gereg.mn/news/50851>, <http://gogo.mn/r/qq2dy>, <http://zuv.mn/n1j>, https://newswire.mn/?p=8222&fbclid=IwARONKgh18M7x7oPCdedWdWZ9ziYXV7Ka_anulYsasc5LGkV9GlxfqOg_bg0 зэрэг сайтаар олон нийтэд хүргэлээ. Мөн байгууллагын вэб хуудас, сошиал медиагаар дамжуулан 1200 гаруй хүнд хүргэлээ.

11-р сарын 6-нд Нээлттэй Нийгэм Форумтай хамтран зохион байгуулсан их дээд сургуулийн багш нараар дамжуулан кино хэлэлцүүлгээр хүний эрхийн боловсрол олгох нь уулзалтад МУИС-ийн Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр, Дотоод

хэргийн их сургууль, Шихихутуг, Орхон, Их засаг, Монголын Үндэсний их сургууль зэрэг хууль зүйн их дээд сургуулиудын хүний эрх, олон улсын эрх зүйн багш нар оролцож санал бодлоо солилцлоо.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1989 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халах тухай 2-р Нэмэлт Протоколд нэгдэн орсон Казакстан улсын элчин сайдад талархал илэрхийлж, цаашид цаазаар авах ялыг бүрэн халахыг уриаллаа.

Казакстан улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халах тухай 2-р Нэмэлт Протоколд гарын үсэг зурсан нь тус улс энэ гутамшигт ял шийтгэлийг ардаа орхисон улс үндэстнүүдтэй нэгдэхэд тун ойрхон ирснийг харууллаа. Европ ба Төв Азийн орнуудаас ОХУ, Тажикстан, Беларусь нь ИУТЭОУП-ын 2-р Нэмэлт Протоколд гарын үсэг зураагүй, соёрхон батлаагүй үлдсэн гурван улс юм. Беларусь улс бүс нутагтаа цаазаар авах ял гүйцэтгэдэг цор ганц улс хэвээр байна.





ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ КАМПАНИТ АЖИЛ

УИХ-аас 2020 оны 1-р сарын 23-нд Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан ба тус хуульд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Комиссын гишүүнтэй болохоор тусгаж өгсөн нь Монгол улс 2014 онд нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт Протоколын дагуу байгуулах ёстой Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг хэрэгжүүлэх алхам боллоо.

1 дүгээр сарын 29-нд Монголын Эмнести Интернэшнлээс хорих газарт хараат бус, хөндлөнгийн хяналт шалгалт хийж, тус газарт Т.Чимгээ өлсгөлөн зарласан, эс зарласан тухай зөрүүтэй мэдээллийн бодит үнэнг олон нийтэд мэдэгдэхийг Хүний Эрхийн Үндэсний Комисст хандан уриалж, Т.Чимгээ, Б.Содномдаржаа нарын болоод бусад этгээдийн эрүү шүүлтэд өртсөн гэх бүх хэргийг хараат бусаар мөрдөн шалгах механизмыг бий болгож, шударга шүүхээр хэргийг түргэн шуурхай шийдвэрлэж, үр дүнг олон нийтэд мэдээлэхийг засгийн газраас шаардсан мэдэгдлийг гаргав.

5-р сарын 25-нд Монгол Улсад 2020 оны зургаадугаар сард болох Парламентын сонгуулийн өмнө хүмүүсийг олон шалтгаанаар, түүний дотор цахим болон цахим бус орчинд эрх баригчдыг шүүмжилж, үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө баривчилж, хорих нь нэмэгдэж байгаа ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэн, ердөө эрх баригчдыг шүүмжилснийхээ төлөө хоригдож байгаа бүх хүнийг яаралтай, ямар ч болзолгүйгээр суллахыг шаардсан хэвлэлийн мэдээ гаргалаа.

Монголын Эмнести Интернэшнлээс хүний эрхийн ТББ-ын Форумтай хамтран Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар

санал хүргүүлсэн. Мөн энэ хуультай холбогдуулан гарах журам нь хүний эрх, эрх чөлөөг хангасан байх ёстойг баталгаажуулахыг уриалсан албан бичгийг Харилцаа холбооны зохицуулах газар, Цагдаагийн Ерөнхий газарт тус тус илгээлээ. Цагдаагийн Ерөнхий газраас хариу өгч, журам боловсруулахдаа анхаарч ажиллахаа мэдэгдсэн байна.

“Монгол улс: 2020-2024 онд ажиллах Улсын Их Хуралд санал болгох хүний эрхийн хэлэлцэх асуудал” баримт бичгийг боловсруулан гаргаж, УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн ба үүнд шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдийг Монгол Улсын хүний эрхийн үзүүлэлтийг сайжруулах, хүний эрхийг хүндэтгэн хамгаалахаа нотлон харуулахыг Монголын Эмнести Интернэшнлийн олон мянган гишүүд дэмжигчдийн өмнөөс уриаллаа. Мөн шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх, эрүүдэн шүүхтэй тууштай тэмцэх, хүрээлэн байгаа орчны асуудлаарх хүний эрхийн зөрчлийг зогсоох, орон байртай байх эрхийг хамгаалах, чанартай хүний эрхийн боловсрол олгох, хүний эрх хамгаалагчдыг айлган сүрдүүлэлт, заналхийллээс хамгаалах хууль эрх зүйн орчин бий болгох зэрэг асуудлаарх зөвлөмжүүдийг багтаасан албан бичгийг боловсруулан гаргаж, УИХ-ын 76 гишүүдэд хүргүүлээ. УИХ-ын зарим гишүүдээс хэлэлцэх асуудал дээр хамтран ажиллахаа хариу мэдэгдлээ.

6-р сарын 26 буюу Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрөөр эрүүдэн шүүхээс ангид байх эрхийг таниулах постер, видеог сошиал медиагаар түгээж, давхардсан тоогоор 3500 орчим хүнд хүргэлээ.

ХЭҮК-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах нээлттэй сонсголд ажиглагчаар оролцож, мөн нэр дэвшигчдээс хүний эрх, эрх чөлөөг хэрхэн хангаж ажиллахыг нь тодрууллаа.

Эмнести Интернэшнлийн Зүүн Азийн бүсийн тайланд багтсан Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх тайланг Ковид-19 цар тахлаас сэргийлэх хөл хорио тогтоосны улмаас цахимаар түгээж, 1000 орчим хүнд хүргэлээ.



ЭРСДЭЛД БҮЙ ХУВЬ ХҮМҮҮС КАМПАНИТ АЖИЛ

Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдлыг хэлэлцэх НҮБ-ын хүний эрхийн Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэгт мэдээлэл бэлтгэн илгээлээ. Монгол улсын хүний эрхийн нөхцөл байдлын талаарх уг тайлан илтгэлийг Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад илгээж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа асуудалд анхаарал хандуулан зөвлөмжийн хэрэгжилтийг шаардахыг уриаллаа.



2020 оны УИХ-ын сонгуулийн өмнө Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигч болоод тус байгууллагыг төлөөлөх хүн сонгуультай холбоотойгоор юу хийж болох,

болохгүй талаарх удирдамжийг багтаасан “2020: Хүний эрх ба УИХ-ын сонгууль” мэдээллийг гаргаж, вэб сайт, социал сүлжээгээр гишүүд, дэмжигчдэд хүргэлээ.

Хонгконгийн цагдаа нар тайван замаар эсэргүүцлээ илэрхийлэгчдийг хүчээр тарааж байгааг МЭИ-ийн гишүүд дэмжигчид эсэргүүцэн, видео, мэдээ мэдээллийг сошиалаар түгээлээ. Хятад улс 6-р сарын 30-нд Хонконгт үндэсний аюулгүй байдлыг хамгаалах хууль баталснаа мэдэгджээ. Тус хуулиар гадны хүчтэй хамтарч салан тусгаарлах, хорлон сүйтгэх, терроризм, хуйвалдааны хэрэг үйлдсэн бол 3 жилээс бүх насаар нь хорих хүртэл ял оногдуулах аж. Мөн Хятадын засгийн газраас өөрсдийн хууль сахиулагчдаас бүрдсэн, тодорхой хэргүүд дээр шүүн таслах ажиллагаа явуулах эрх бүхий Хонконгт үндэсний аюулгүй байдлыг хамгаалах оффис байгуулах гэж байгаа нь тодорхой нөхцлүүдээр сэжигтнийг

эх газар руу шилжүүлэн хорьж, шүүх ажиллагаа явуулах боломжтой болж байгаа ба үндэсний аюулгүй байдалд халдсан хэрэгт буруутгагдаж байгаа хүн бүрийн шударгаар шүүлгэх эрх зөрчигдөхөд хүргэж байна. Лхагва гарагт болсон эсэргүүцлийн үеэр хэд хэдэн хүн баривчлагдсан ба долоо нь үндэсний аюулгүй байдлын хуулийг зөрчсөн хэмээн цагдаа мэдэгджээ. Баривчлагдсан нэг хүний цүнхнээс “Хонконгийн тусгаар тогтнол” туг олдсон байна. Олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээгээр тайван замаар тусгаар тогтнолын талаарх үзэл бодлоо илэрхийлэх нь үндэсний аюулгүй байдалд заналхийлсэнд тооцогддоггүй.

ӨМӨЗО-нд монгол хэл соёлоо хадгалж үлдэхээр тайван замаар тэмцсэн хүмүүс халдлагад өртөөд байгаа тухай мэдээллийг вэб сайтаар түгээж, гишүүд дэмжигчид яаралтай үйл ажиллагаа өрнүүллээ.

ОХУ-д Ковидын үеэр эмч, эмнэлэгийн ажилтны эрхийн төлөө дуугарсан эмч Татьяна Реввагийн төлөө гишүүд сургалт, уулзалт, бүх гишүүдийн улирлын уулзалтаараа үйл ажиллагаа өрнүүлж, түүний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэхгүй байхыг уриалсан захидлыг Волгоград мужийн прокурорт илгээлээ.

Ковид 19 цар тахлын тархалтыг зогсоох хөл хорионы улмаас Эрхийнхээ төлөө бичигцгээ 2020 аяныг цахим орчинд зохион байгууллаа. Уг аяны хүрээнд Колумб, Бурунди, Өмнөд Африк, Мьянмар, Чили, Саудын Араб, Алжир, Малта, Турк, Пакистан улсад сураггүй алга болсон хэргийг илчилж, цэрэг армийн авилгалыг шүүмжилж, газар нутгаа хамгаалж, эмэгтэйчүүдийн эрхийг шаардаж, сэтгүүлчийн ажлаа эрхэлж явахдаа, ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалж үгээ хэлж үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө эрх нь зөрчигдсөн хувь хүн, бүлэг хүмүүсийн төлөө цахим уриалга өрнүүллээ. Цахим уриалгад 2831 хүн нэгдсэн байна.



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ -ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ТӨЛӨӨ КАМПАНИТ АЖИЛ

ХУУЛИЙН ХАМГААЛАЛТ БИЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ

Бид орон байртай байх эрхийг хамгаалах “Төр үүргээ мэд, биелүүл” кампанит ажлаараа “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль” болон түүнийг хэрэгжүүлэх журмуудад олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн хүний эрхийн хамгаалалт бүхий нэмэлт, өөрчлөлт оруулахын төлөө ажиллаж байгаа билээ.

- Дахин төлөвлөлтөд хамрагдаж, төсөл хэрэгжүүлэхээр ирсэн компанитай холбогдох хууль, тогтоомжийн дагуу тохиролцож чадаагүй байхад нь хүч албадлага хэрэглэн нүүлгэсэн тухай иргэний гомдолд үндэслэн олон улсын хүний эрхийн тухай хууль, хэм хэмжээгээр хамгаалагдсан орон байртай байх эрхийг хамгаалах стратегийн өмгөөлөл хийлгэдэг болгохоор уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгууллаа.

Дахин төлөвлөлтөд хамрагдаж орон гэргүй болсон, түрээсийн төлбөрөө авч чадахгүй байгаа болон ямар нэгэн байдлаар эрх нь зөрчигдсөн иргэдийн бодит тохиолдолд үндэслэн “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд: Орон байртай байх эрхийг хангаж, хамгаалах эрх зүйн

Зорилтууд:

1. Хуулийн хамгаалалтыг бий болгохын төлөө
2. Эрхээ мэддэг, хамгаалдаг, шаарддаг соёлыг бий болгохын төлөө

орчин, хэрэгжилт” сэдвээр хуульчдын баг ажилласан. Энэхүү баг нь одоо мөрдөж буй холбогдох хууль тогтоомж нь иргэдийн орон байртай байх эрхийг дахин төлөвлөлтийн хүрээнд хамгаалж чадаж буй эсэхийг нягтлан, хамгаалалт тусгуулах санал, зөвлөмж боловсруулах зорилготой байв.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хөтөлбөрүүдэд 2013 оноос эхлэн хамрагдаж, 6-7 орчим жил орон гэргүй тэнүүчлэн амьдарч байгаа эсвэл аливаа байдлаар төсөл хөтөлбөрөөс хохирсон иргэдийн ярилцлага, бодит нөхцөл байдалд тулгуурлан хийсэн уг судалгаа нь холбогдох хууль тогтоомжид олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн хамгаалалт суулгах, болон цаашид ийм алдаа дахин гаргуулахгүйн тулд





Улаанбаатар хотын дахин төлөвлөлтийн хүрээнд шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь зөрчигдсөн иргэдийн асуудлыг эрх зүйн талаас нь хөндөн гаргаж, олон нийт, хэвлэл мэдээлэл, гүйцэтгэх засаглал, хууль тогтоогчдын анхаарлын төвд хүргэж байгаагаараа энэхүү судалгааны ач холбогдол оршиж байв.

Улаанбаатар хотод дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжээд 7 орчим гаруй жил болж буй ч хууль, эрх зүйн орчны хийдэл, зөрчил, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоогүй байдал, хэрэгжүүлэлт, зохион байгуулалтын алдаа болон хяналт тавих, хариуцлага тооцох зэрэгт нэгдсэн удирдлага, арга зүй хангалтгүй, сул байгаагаас дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч барилгын компаниудын зүгээс төсөлд хамрагдсан иргэдэд учруулж буй эрсдэл, тулган шаардалт, хор хохирол байсаар, иргэдийн олон улсын хүний эрхийн тухай хуулиар хамгаалагдсан орон байртай байх эрх зөрчигдсөөр байна. Орон байртай байх эрхээ зөрчүүлж, дахин төлөвлөлтийн хохирогч болсон иргэдийг түр болон бүр орон сууцаар хангах, хохирлыг нь барагдуулах ажил бүрэн, гүйцэд хийгдээгүй байхад Хан-Уул дүүргийн 4-8 дугаар хороодод дахин төлөвлөлтийг далайцтай эхлүүлж буй нь сэтгэл зовоосон асуудал болоод байна. Тиймээс дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг хариуцан

хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудын тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, дотоод хяналтын үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт чиглэлээр Төрийн аудитын тухай хуулийн 2021 онд аудит хийлгэх хүсэлт гаргасан.

ЭРХЭЭ МЭДДЭГ, ХАМГААЛДАГ, ШААРДДАГ СОЁЛЫГ БИЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хүний эрхийн болон тэр дундаа шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийн тухай мэдлэг хомс, төрийн албан хаагчид болон төсөл хэрэгжүүлэгч барилгын компаниуд иргэдийг дахин төлөвлөлтийн талаарх мэдээллээр хангах үүргээ бүрэн, шуурхай биелүүлэхгүй байгаагаас үүдэн иргэд хохирсоор байгаа тул эрхээ мэддэг, хамгаалдаг, шаарддаг соёлыг бий болгох хэрэгцээ их байна.

“Ковид-19 цар тахлын эсрэг нэн тэргүүний хамгаалалт бол Орон байр юм” гэж НҮБ-ын Тусгай Илтгэгч 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдөр мэдэгдсэн билээ. “Орон байр нь шинэ коронавирустэй тэмцэх нэн тэргүүний хамгаалалт болоод байна. Дэлхий даяар Засгийн газрууд шинэ коронавирусийн тархалтаас урьдчилан сэргийлэхийн тулд төр иргэдэд орон гэргүй болохоос хамгаалах, нүүлгэн шилжүүлэлт хийхийг хориглох, орон гэргүй хүмүүсийг зохих орон байртай болох боломжоор хангах яаралтай арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна” гэж НҮБ-ын Тусгай Илтгэгч мэдэгдэв.

Эмнести Интернэшнлийн зүгээс Засгийн газруудад хандан Ковид-19 халдварт өвчний эсрэг авч буй бүхий л арга хэмжээнийхээ үеэр хүний эрхийг хүндэтгэн, хангаж ажиллахыг уриалсан албан бичгийг дээрх НҮБ-ын Тусгай илтгэгчийн мэдэгдлийн хамт нийслэлийн Засаг дарга болон холбогдох удирдлагууд, Барилга, хот байгуулалт, Эрүүл мэнд, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон



БСШУС-ын сайд нарт тус тус хүргүүлсэн. Энэ нь “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-д тусгагдсан нь Эмнести Интернэшнлээс хүний эрхийг хамгаалах үйлсэд оруулсан хувь нэмэр байсан.

ОББЭ-ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧ ТӨСӨЛ


Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хамгаалах зорилготой “ОББЭ-Эрх зүйн хөтөч” төслийг бид хэрэгжүүлж байна. Завхан, Архангай аймаг болон нийслэлийн 6 дүүрэгт хэрэгжих уг төсөл нь сургалт, хэлэлцүүлэх хийх зэрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны зэрэгцээ иргэдийн үндсэн хэрэгцээ, үндсэн эрх болох орон байрных нь асуудлаар хууль зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилготой.

Ковид-19 цар тахлаас үүдэн улс орон даяар онц байдал тогтоосны улмаас ОББЭ-Эрх зүйн хөтчийн төсөл төлөвлөгөөний дагуу хэрэгжих боломжгүй болсон тул үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан цахимаар ажиллах бэлтгэл, туршилт хийн үйл ажиллагааг илүү олон нийтэд хүргэхээр дараах ажлыг хийсэн. Үүнд:

Иргэдэд орон байртай байх эрхийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор “Эрх зүйн хөтөч нар-Орон байртай байх эрх, нүүлгэн шилжүүлэлт нэртэй фэйсбүүк пэйж хуудас” ажиллуулж, эрх зүйн хөтөч нар мэдээлэл, постер оруулж байна. Уг пэйжид 610 хүн нэгдэж, 638 хүн тогтмол дагадаг бөгөөд нийт 653 мэдээ, мэдээлэл оруулжээ. Түүнчлэн эрх зүйн хөтөч нар биечлэн 423 хүнд, хурал уулзалтаар 455 иргэнд хүний эрхийн ялангуяа орон байртай байх эрхийн талаар нийт 878 зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллажээ.

Орон байртай байх эрхийн эрх зүйн хөтөч нараа пэйжээрээ сурталчилж, тэднийг эрх зүйн хөтчийн подкаст ярилцлагад урьж оруулцуулан цахимаар мэдээлэл түгээх боломжийг эрэлхийллээ. Түүнчлэн эрх зүйн хөтөч нар БЗД-ийн 12 дугаар хорооны Иргэний танхимд эрх зүйн зөвлөгөө өгч, иргэдэд хэрэгтэй мэдээ, мэдээллийг “и хөтөч” цахим сайт болон бусад эх сурвалжаас хэвлэж өгдөг болсон нь иргэдийн зүгээс өндөр үнэлгээ авсан.

Эрх зүйн хөтөч нарын чадавх бэхжүүлэх сургалтыг цахимаар зохион байгуулсан. 7 өдрийн 38 цагийн энэхүү сургалт нь цахим боловсрол олгосон онцлогтой байв. Гэвч, УИХ-ын сонгууль, ковид 19, болон ухаалаг гар утас, зөөврийн компьютер, интернэт холболт зэрэгтэй холбоотойгоор эрх зүйн хөтөч нарын зарим нь цахим сургалтдаа бүрэн хамрагдаж чадаагүйтэй холбоотой сургалтын 14 видео бичлэгийг бэлдэн эрх зүйн хөтөч нартаа түгээлээ.



КОВИД-19 ба ХҮНИЙ ЭРХ

Эмнести Интернэшнлээс Ковид-19 цар тахлын үед хүний эрхийг дээдлэх нь энэхүү өвчинтэй тэмцэх гол арга болох талаар дэлхийн улс орнуудын Засгийн газарт зөвлөсөөр ирлээ. Энэ хүрээнд “Улс орнуудын Ковид-19 вирусийн халдварын эсрэг авч буй арга хэмжээ болон хүний эрхийг хангах үүрэг хариуцлага: эхний ажиглалт” тайланг 2020 оны 3 дугаар сард, /https://amnesty.mn/images/2020/04/03/Covid-19_.pdf/; “Заналхийлэл, хүчирхийллийн дор дуугарах эрхгүй, нүцгэн гараар Ковид-19 цар тахлын эсрэг тэмцэгсэд” /Ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хамгаалж чадахгүй байна/ тайланг 2020 оны 07 дугаар сард тус тус гаргасан. /<https://amnesty.mn/index.php/book-library/155-resources/online-news/2018-12-30-08-36-21/583-2020-10-16/>

Энэ 2 тайлангийн хүрээнд Монголын Эмнести Интернэшнлээс гишүүд, дэмжигчид болон эрүүл мэндийн 100 гаруй ажилтан, албан хаагчдын дунд уулзалт, хэлэлцүүлэг удаа дараа зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, хүсэлт, зөвлөмжийг Эрүүл мэндийн яамны удирдлагуудад хүргэлээ.

Эмнести Интернэшнлийн “Улс орнуудын Ковид-19 вирусийн халдварын эсрэг авч буй арга хэмжээ болон хүний эрхийг хангах үүрэг хариуцлага: эхний ажиглалт” тайлангийн хураангуйг Хүний эрхийн Үндэсний Комиссын “Хүний эрх сэтгүүл”-ийн 2020/01 дугаарт нийтэлж, олон нийтийн хүртээл болгосон. Түүнчлэн тус сэтгүүлийн уг дугаар нь Legalddata.mn вэб сайтын 11 дүгээр сарын эрэлттэй бүтээлээр шалгарчээ. Ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хамгаалах тухай тайлантай холбоотой мэдээллийг уулзалт, хэлэлцүүлгээс гадна өдөр тутмын хэвлэлд өгсөн ярилцлагаар олон нийтэд түгээлээ. <https://unuudur.mn/>б-алтантуяа-эмч-нарт-илүү-их-хамгаалалт-хэрэгтэй-байна/

Эрүүл мэндийн яамны удирдлагуудтай биечлэн болон цахимаар хийсэн уулзалтад Хүний эрхийн Үндэсний Комиссыг оролцуулж, "Эмч, эмнэлгийн ажилтан, зайлшгүй шаардлагатай ажилтны эрх"-ийн асуудлаар болон Ковид-19-тэй тэмцэхэд дэлхий нийтэд тулгарч буй эрүүл мэндийн салбарын бэлэн байдал, бэлтгэл хангах асуудлууд Монгол оронд ч ижилхэн байгаа талаар санал солилцов.

Монголын Эмнести Интернэшнлийн зүгээс нэн тэргүүнд эмч, эмнэлгийн ажилтнуудыг хамгаалах, хувийн хамгаалах хэрэгслийн хомсдолгүй байлгах, тэдний ажиллах нөхцөлийг сайжруулах талаар анхаарч ажиллахыг уриалсан. Уулзалтаас төрийн зүгээс зайлшгүй хийх, анхаарах, шийдэх асуудал олон байгаа нь харагдаж байсан.

Эмнести Интернэшнлээс "Ковид-19 ба Хүний эрх" сэдвээр тактикийн кампанит ажил эхлүүлсэнтэй холбоотой Олон улсын төвөөс эрхлэн гаргасан мэдэгдэл, нийтлэл, баримтат кино, тайлан зэргийг орчуулж, мэдээ, мэдээлэл, постер бэлтгэн цахим болон хэвлэмэл байдлаар гишүүд, дэмжигчид, иргэний нийгмийн байгууллага, төрийн холбогдох байгууллага болон олон нийтэд хүргэж ажиллав.

Түүнчлэн Корона вируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн төсөлд санал хүргүүлснээр тодорхой зарим саналаа уг хуульд тусгуулсан. Ковид-19 цар тахлын үед хүний эрхийг бүх түвшинд дээдлэн ажиллах нь цар тахалтай нийтээрээ амжилттай тэмцэн даван туулах арга болохын зэрэгцээ энэ үед нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд онцгой анхаарал тавьж ажиллахыг Засгийн газарт уриалав.



КОВИД-19

ХИЙЖ
БОЛОХ ЗҮЙЛС

БИЕ БИЕДЭЭ ХҮЛЭЭЦТЭЙ ХАНДАХ
ӨНДӨР НАСТАН ГЭХ МЭТ ЭМЗЭГ БҮЛГИЙНХЭНДЭЭ АНХААРАЛ
ХАНДУУЛАХ
ЭМБ-Н БАЙГУУЛЛАГЫН ЗААВАРЧИЛГАА БОЛОН ХӨЛ ХОРИОНЫ
ҮЕИЙН ЗААВАРЧИЛГААГ ДАГАЖ МӨРДӨХ
ГАРАА ТОГТМОЛ УГААХ

ХИЙЖ
БОЛОХГҮЙ ЗҮЙЛС

БУРУУ ТАШАА МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ
БУХИМДАЛ АРЬС ӨНГӨӨР ЯЛГАВАРЛАХ ҮЗЭЛ АГУУЛСАН
КОММЕНТ СЭТЛЭГ ДЭЛ ҮЛДЭЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ
АМЬДРАЛЫН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛСИЙГ
ЗӨВХӨН ХЭРЭГЦЭЭНИЙХЭЭ ХЭМЖЭЭГЭЭР ХУДАЛДАН
АВЧ БУСДАД ҮЛДЭЭХ

БАТ ЗОГС



ХОЛ

байгаа ч

ХАМТДАА

БИД НЭГДВЭЛ
КОВИД-19-ТЭЙ ТЭМЦЭЖ
ЧАДНА.

БИД ХАМТДАА ЭНЭ ӨВЧНИЙГ
ДАВАН ГАРАХ БОЛНО.



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ КАМПАНИТ АЖИЛ

Зорилтууд

1. Гишүүд, дэмжигчид, малчид, иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтэд сургалт, хэлэлцүүлэг хийн чадавхжуулах
2. Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийн сургуулиудыг дэмжих, хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх
3. Төрөл бүрийн салбарт түншлэл тогтоох, тэднийг хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд татан оролцуулах



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

- Философи-хүний эрхийн уулзварт олимпиадыг зохион байгуулах талаар Ажлын хэсгийн уулзалтыг цахимаар хийлээ. Уулзалтад МУИС, ШУТИС, АШУИС, ХААИС, МЭИ зэрэг байгууллагууд оролцож, Ковид-19-ийн эсрэг Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний дагуу олимпиадаа хойшлуулж, 2020-2021 оны хичээлийн жилд хийх боллоо.
- 2020 оны Эрхээ мэдье мэтгэлцээний тэмцээний тэмцээнийг Ковид-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулагчдыг

амны хаалт, нийт мэтгэлцэгчдийг гар ариутгалын бодисоор хангахын зэрэгцээ оролцогч бүрийн халууныг хэмжин халдвар, ариутгалын арга хэмжээг чанд хэрэгжүүлж зохион байгууллаа. Тэмцээн дараах онцлогтой байв. Үүнд:

- ✓ Гурван хоног 30 гаруй цаг мэтгэлцэж, аварга багаа тодруулсан.
 - ✓ Хот, хөдөөгийн 132 багийн 396 мэтгэлцэгч хүч чадлаа сорьсон.
 - ✓ Хот, хөдөөгийн 100 гаруй багш хүүхдүүдээ бэлтгэж, оролцуулсан.
 - ✓ Тэмцээний нээлтэд 500 гаруй хүн оролцож, хүний эрх хамгаалагч залуучуудын түүхээс сонссон.
 - ✓ Хүний эрхийн мэдрэмжтэй шилдэг мэтгэлцэгчийг анх удаа шалгаруулсан.
 - ✓ Эрхээ мэдье мэтгэлцээний тэмцээний тунхаглалтай болсон.
 - ✓ МЭИ-ээс анх удаа 8 үндсэн, 8 туслах шүүгчийн бүрэлдэхүүнтэй оролцож, шүүсэн.
 - ✓ Эрхээ мэдье мэтгэлцээний шүүгч гэсэн Эмнести Интернэшнлийн тэмдэг гардуулсан.
 - ✓ Тэмцээнд оролцогчид МЭИ-ээс хэвлэсэн ном, товхимлыг ашиглан, асуудалд хүний эрхийн өнцгөөс хандаж буй нь нэмэгдсэн зэрэг болно.
- Тэнцэтгэлийг өөрчилье-Нөхөрсөг жаалууд сургалтыг цахим болгож, Завхан, Баян-Өлгий, Архангай аймгийн хүүхэд, залуучуудад хүргэж, туршсан. Түүнчлэн тус сургалтыг цахимаар болон танхимын сургалтаар заах сургагч багш нарыг бэлдэн 15 сургуулийн 340 хүүхдэд хүрлээ. Бусдын ялгаатай байдлыг ойлгож, хүндлэх соёл бий болгох болон шоглох, дээрэлхэх, дарамтлах нь хүний эрхийн зөрчил болох талаар өсвөр үеийнхний дунд хэлэлцүүлэг өрнүүлж, цаашид хэрхэх талаар анги, хамт олноороо гаргалгаа




гаргах зорилго бүхий уг сургалт нь Монголын Эмнести Интернэшнлийн брэнд ажлын нэг болж, хэрэгцээ шаардлага нь огцом өссөн.

- Францын Аббе Пьех Сан, ПАДЕМ байгууллагын дэмжлэгтэйгээр олон нийтийн оролцоотой иргэдийн орон байрыг сайжруулах төсөлд түншлэгч Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, Монголын Эмэгтэйчүүдийн Сан, Монголын Багш Эцэг эхийн Холбоо, Эрүүл Саруул Амьдрахүй ТББ-уудад олон нийтийг идэвхжүүлэх сургагч багш бэлтгэх, хүний эрх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх мэдлэг мэдээллийг олгох цуврал цахим сургалтын Хүний эрхийн тухай, Эрх зүйн тусламж зөвлөгөө болон Газар өмчлөх эрхтэй холбоотой хэсгийг Монголын Багш Эцэг эхийн Холбооны хүсэлтээр зохион байгуулж, сургагч багш нараар хангав.
- Хүний эрх, эрх чөлөө - шог зургийн үзэсгэлэн №2: Энэ жилийн Шог зургийн үзэсгэлэнгийн онцлог нь:
 - ✓ Монгол улсад цар тахлыг дотооддоо алдаж, хөл хорио тогтоосонтой холбоотой цахим үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэнг Сүхбаатарын талбай, Цэцэрлэгт хүрээлэн гэсэн 2 цахим танхимд дэлгэн үзүүлсэн.
 - ✓ Нийт 15 зураачийн 120 гаруй бүтээлийг дэлгэн үзүүлсэн.
 - ✓ Үзэсгэлэнгийн үзмэрүүд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдсон 2020 оны шинэ бүтээлүүд байсан.

- ✓ Шинэ залуу шог зураачдын бүтээлээс дэлгэсэн.
- ✓ Ковид-19 цар тахалтай холбоотой хүний эрхийн асуудлаар бүтээлүүд олон байсан.
- ✓ Үзэсгэлэнд ирүүлсэн хүний эрхийн сэдэвтэй бүтээлүүдийг 4500 гаруй хүн цахимаар үзсэн.

Тус үзэсгэлэнг цахимаар зохион байгуулснаар хүний эрхийн асуудал, хүний эрхийн зөрчлийг урлагийн бүтээлд тусган, улмаар урлагаар дамжуулан олон нийтэд хүний эрхийг түгээн дэлгэрүүлсэн сайн ажил болсон талаар МЭИ-ийн гишүүд, дэмжигч, хамтрагч нараас санал, сэтгэгдэл ирүүлжээ.

- МЭИ-ийн жил бүрийн хүний эрхийн төлөө үйлсэд хувь нэмрээ оруулсан оюутан залуус, сэтгүүлчдэд зориулсан "Белинда" тэтгэлэгт хөтөлбөр амжилттай боллоо. Хөтөлбөрийн оролцогчид бүтэн жилийнхээ үйл ажиллагааг дүгнэж, Оюутны бүлгийн гишүүн Г.Сүхбат, Сэтгүүлчдийн бүлгийн гишүүн Д.Мягмаржаргал нар тэтгэлгийн эздээр тодорсон.
- Эмнести Интернэшнлийн үүсгэн байгуулагдсан өдрийг угтан жил бүрийн 5 дугаар сарын 28-ны өдөр бид "Ярьдаг Футболка" хүний эрхийн өдөрлөгийг зохион байгуулдаг билээ. Цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан энэ жил бид өдөрлөгөө цахимаар зохион байгуулсан. Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, олон нийтэд хүргэх зорилготой уг өдөрлөгт ХЭЭС хөтөлбөрийн сургуулиуд, МЭИ-ийн нийслэлийн



BAT-ERDENE ADIYA


АДЪЯАГИЙН БАТ-ЭРДЭНЭ

MUNKH-ERDENE.M

М.МОНХ-ЭРДЭНЭ

AMARSAIKHAN ALTANGEREL

АЛТАНЭРЭЛИЙН АМАРСАЙХАН

«HUMAN RIGHTS, FREEDOM»
AMNESTY INTERNATIONAL MONGOLIA«ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ»
МОНГОЛЫН ЭРХЭНД Х АЖИЛЛАГАА«HUMAN RIGHTS, FREEDOM»
AMNESTY INTERNATIONAL MONGOLIA«ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ»
МОНГОЛЫН ЭРХЭНД Х АЖИЛЛАГАА«HUMAN RIGHTS, FREEDOM»
AMNESTY INTERNATIONAL MONGOLIA«ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ»
МОНГОЛЫН ЭРХЭНД Х АЖИЛЛАГАА

BAT-ERDENE ADIYA

АДЪЯАГИЙН БАТ-ЭРДЭНЭ

«HUMAN RIGHTS, FREEDOM»
AMNESTY INTERNATIONAL MONGOLIA«ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ»
МОНГОЛЫН ЭРХЭНД Х АЖИЛЛАГАА



болон орон нутгийн гишүүд, дэмжигчид идэвхтэй оролцож, хүний эрхийн мессэж бүхий богино цамц урлалын уралдааны шилдгүүдээ тодруулав. Цар тахлаас үүдэн анх удаа цахимаар хийсэн уг өдөрлөг нь хүүхэд, өсвөр үеийнхнийг хүний эрхэд татан оролцуулсан, идэвхжүүлсэн ажил болов.

- Эмнести Интернэшнлийн “Эсэргүүцэл илэрхийлэх эрх”, “Эсэргүүцэл илэрхийлэх эрхээ хэрхэн хамгаалах вэ?” болон “Жагсаал, цуглааны үеэр дэг журам сахиулах зөв арга бий юу?” зэрэг хүний эрхийн богино хэмжээний цуврал видеог олон нийтэд нийгмийн сүлжээгээр түгээсэн. Энэ нь хүний эрхийн боловсролыг бүх насны иргэдэд түгээх сүүлийн үеийн шилдэг аргуудын нэгэн болоод байна.

ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ СУРГУУЛЬ ХӨТӨЛБӨРИЙГ ДЭМЖИХ

Эмнести Интернэшнлийн “Хүний эрхэд ээлтэй сургууль” хөтөлбөр нь сургуулийн удирдлага, харилцаа, сургалтын хөтөлбөр/хичээлээс гадуурх үйл ажиллагаа болон сургуулийн орчин зэрэг сургуулийн бүх үйл ажиллагаанд хүний эрхийг дээдэлсэн бодлого, дүрэм, журам гаргаж, хамтаараа хэрэгжүүлснээр хүний эрхийн соёл, хандлага төлөвшүүлэх зорилготой юм.

Эмнести Интернэшнлийн Хүний эрхийн Академийн “ХЭЭС болох нь” цахим сургалтыг Монгол хэлнээ хөрвүүлж, сургалтаа цахимаар хийхээр ажилласан.

- “Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь” сургалтыг Логирифм дунд сургуулийн хамт олонд зохион байгуулснаар тэд хүний эрхийн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцож эхэлсэн. Түүнчлэн Улаанбаатар Эмпати сургуулийн хамт олон ХЭЭС хөтөлбөрт нэгдэх хүсэлт тавьснаар Тэнцэтгэлийг өөрчилье сургалтыг тэдний багш нарт явуулж, сургагч багш нарынхаа эгнээг тэлсэн.
- “Хүний эрхийг ээлжит хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь” цахим хичээл бэлтгэх багш нарын ур чадварын уралдааныг ХЭЭС хөтөлбөрийн сургуулиудын дунд зохион байгуулав.

Уралдааны удирдамжийг утсаар, Хүний эрхэд ээлтэй сургууль хаалттай Фэйсбүүк бүлгээр, ХЭЭС-ийн сургуулиудын удирдлагуудын цахим хаягаар болон МЭИ-ийн Фэйсбүүк пэйж, вэб сайтаар багш нарт хүргэхийн зэрэгцээ багш нарыг идэвхжүүлэх видео бичлэгийг хийж түгээлээ. Уралдаанд Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрт хамрагдсан Эрдэнэт хот, нийслэлийн сургуулиудын багш нар түүх, нийгмийн ухаан, эрүүл мэнд, монгол хэл, математикийн хичээлээр хүний эрхийг тусгасан 8 видео хичээл зааж ирүүлсэн. Улаанбаатар Эмпати сургуулийн түүхийн багш Д.Мөнхцэцэг уралдааны



тэргүүн байрыг, Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн багш Э.Энхчимэг дэд байрыг, Монгени цогцолбор сургуулийн багш Г.Байгалмаа гутгаар байрыг тус тус эзэлсэн. Уралдааны эхний 3 байрт шалгарсан бүтээлүүдийг МЭИ-ийн вэб хуудас, фэйсбүүк пэйж, Хүний эрхэд ээлтэй сургууль группээр тавьж олны хүртээл болгосон.

- Ковид-19 ба хүний эрх сургалтыг Хүний эрхэд ээлтэй сургуулийн багш нарт зааснаар тэд тус тусын сургууль, хамт олон, даасан ангидаа мэдээлэл түгээх сургалт зохион байгуулцгаасан. Ковид-19 цар тахлыг амжилттай даван туулахад ялгаварлан, гадуурхалгүй хүн хүнээ дээдэлсэн харилцааг төлөвшүүлэх, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хамгаалах, хувийн хамгаалах хэрэгслээр тэднийг хангах болон вирусын эсрэг дархлаажуулалтад хүн бүрийг тэгш хамруулж байж бид бүгд хамгаалагдана гэсэн Эмнести Интернэшнлийн дэлхий дахинаа хийсэн судалгаанууд дээр үндэслэсэн мэдээллүүдийг Завхан, Орхон, Архангай аймгийн болон нийслэлийн хувийн болон төрийн өмчит 10 сургуулийн 300 орчим багш, сурагчид түгээлээ.



- Ковид-19-ийн хөл хорионы улмаас Хүний эрхэд ээлтэй сургуулиудыг идэвхжүүлэх, хийж, хэрэгжүүлсэн ажлыг нь сурталчлах зорилготой цахим сонин гаргах, хөтөлбөрийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэхээр “ХЭЭС-ийн подкаст” ярилцлагын 2 дугаарыг бэлтгэн гаргасан. ХЭЭС хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулж байгаа Л.Нэргүй болон Д.Ихзаяа багш нарын подкаст ярилцлагыг олон нийтэд хүргэж хөтөлбөрөө сурталчиллаа.

Хэдийгээр Монгол Улс 2020 оны эхээр Коронавируст цар тахлын гаднаас зөөвөрлөгдсөн тохиолдлууд, оны сүүлээр цар тахлын халдварыг дотооддоо алдсанаас үүдсэн хатуу хөл хорио, өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдал зэрэг гамшгийн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд нийцүүлэн бид Хүний эрхийн боловсрол, ЭЗНСЭ-ийн КА зэрэг бүх үйл ажиллагаагаа цахим болон цахим бус хэлбэрээр үр дүн гаргахын төлөө ажилласан нь туршилт, сургамжаасаа суралцан амжилтын төлөө тэмүүлсэн жил байлаа.

ЭМНЕСТИГИЙН ЗАЛУУЧУУД: 2020 ОНД



I. ЗАЛУУЧУУДЫГ ИДЭВХЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАТАН ОРОЛЦУУЛАХ ХҮРЭЭНД:

Гишүүн чадавхжуулах, бэхжүүлэх сургалт, хэлэлцүүлэг:

- МЭИ-ийн “Залуучуудын Стратеги төлөвлөгөө”-ний үнэлгээ хийж олон улсын төвийн Youth Power Action-2019 report-д Монголын Эмнестигийн залуучуудын тайлан, мэдээлэл илгээв.
- Үндсэн Хууль ба Хүний эрх- онлайн сургалтад 17 залуу гишүүн;
- “Хувийн халдашгүй байдал ба Биохэмжүүр таних систем 2 өдрийн дотоод сургалтад 3 залуу гишүүн;
- Фронтлайн Дифендерс олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Digital Security Training”-Цахим аюулгүй байдлын сургагч багш бэлтгэх сургалтад 2 залуу гишүүн;
- Нүүрээр таних технологи ба Хүний эрх-онлайн хэлэлцүүлэгт 14 залуу гишүүн; Шинэ гишүүдэд зориулсан танхимын болон цахим 12 удаагийн сургалтад 98 залуу гишүүн тус тус хамрагдав.

Олон улсын хурал, хэлэлцүүлэг:

- Дэлхий нийтийн шинэ стратеги төлөвлөгөөний 2 удаагийн хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 27 залуу гишүүн;
- Шинэ Зеландын Эмнестигийн салбараас зарласан “Shouting out for climate justice” workshop –д 2 залуу гишүүн;
- “Залуучуудын Дэлхий Нийтийн Стратеги төлөвлөгөө”-ний хэлэлцүүлэгт 2 залуу гишүүний төлөөлөл тус тус оролцов.

Дотоодын хурал, хэлэлцүүлэг:

- Залуучуудын иргэний нийгмийн зургаа дугаар чуулган “ЗАЛУУСАА СОНСОЦГООЁ:ЦАР ТАХАЛ БИДНИЙ АМЬДРАЛД” уулзалтад

залуучууд хариуцсан зохицуулагч панелист илтгэгчээр оролцов. МЭИ-ийн 2 залуу гишүүн цахим хэлбэрээр оролцов.

II. ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН МАНЛАЙЛЛЫН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ САНААЧЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНД ЗОРИУЛСАН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДАД ХАНДАХ ХҮРЭЭНД

Уламжлалт арга хэмжээ:

- Ярьдаг Футболк-2020 футболк урлалын уралдааныг зохион байгууллаа. Ярьдаг футболк фэйсбүүк эвэнт 27000 хүнд хүрсэн ба 573 хүн манай эвэнтийг дагасан байна.
- “SWEET SEPTEMBER” Хүний эрхэд ээлтэй сар зарлав. Нийт 46 гаруй залуу хүний эрхийн хамгаалагчид зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцож, 25 цагийг хүний эрхийн төлөө хандивлажээ. Аяны хүрээнд 283 шинэ гишүүн элсүүлжээ.

Хамтрагч байгууллагатай хамтран зохион байгуулсан арга хэмжээ:

- Ирээдүй хойчийн эрхийн төлөөх залуучууд ТББ-тай хамтран залуучуудад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дуу хоолойгоо өргөх, ирээдүй хойчийн төлөө үзэл бодлоо илэрхийлэх талбар болгон цахим орчинд ишлэлийн уралдаан зарлаж, ивээн тэтгэгч, хамтрагч байгууллагаар ажиллалаа.
- Монголын Оюутны Холбоотой хамтран “Хүний эрхэд ээлтэй оюутны байр хөтөлбөр” зарлаж, 51 залууг хүний эрхийн сургагч багшаар бэлтгэв

III. ХҮНИЙ ЭРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БОЛОВСРОЛЫГ ЦАХИМ СҮЛЖЭЭ АШИГЛАН ОЛОНД ТҮГЭЭХ ХҮРЭЭНД:

Дотоодын цахим активизм:

- Ковид-19 ба Хүний эрх-цахим активизм-Дэлхий дахинаа тархаж буй Ковид-19 цар тахлын үед улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд бүгд хүний төлөө байж, хүний эрхийг хүндэтгэхийг уриалж залуучууд активизм өрнүүлж бичлэг хийв.. Тус активизм цахим орчинд 33200 хүнд хүрэв.
- “Намайг сонсооч:Хүний эрхийн төлөө би дуугарч байна” сэдвээр илтгэсэн 4 сурагчийн илтгэлийг цахим орчинд байршуулав. Цахим орчинд 1600 гаруй хүнд хүрсэн байна.
- “Эмнестигийн Залуучууд” medium платформ нээж, хүний эрхийн ерөнхий ойлголт, сайн дурын ажлын тухай, эрүү шүүлтийн эсрэг болон Шоглохын эсрэг сургалтын тухай... гэх мэт сэдвүүдээр нийтлэл бичсэн байна. Нийт 544 хүний хандалт авав.
- Ковид цар тахлын үеийн хөл хорион дахь гэр бүлийн хүчирхийллийн эсрэг

постер бэлтгэж, цахим активизм өрнүүлэв.

- “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл”-ийг УИХ-иар дэмжүүлэх зорилгоор 12 цагийн чаллэнж зарлаж цахим активизм өрнүүлэв. Яаралтай активизмд 56 гишүүн хамрагдав.

Олон улсын цахим активизм:

- Эх дэлхийн өдөрт нэгдэж Канадын Эмнестигийн залуусын #EarthMonth давлагаанд нэгдэв.
- Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхий нийтийн өдөрт зориулан цахим активизм өрнүүлэв. Нэрт жүжигчин Анжелина Жолегийн өсвөр, залуу үеийнхэнд хандан хэлсэн тус яриа 2200 хүнд хүрэв.


Турк улс дахь Хүний эрх хамгаалагчдийн төлөө цахим активизм өрнүүлэв. Тус активизмын хүрээнд [#FreeRightsDefenders](#) [#Turkey](#) [#HakSavunucularıİçinAdalet](#) хаштагийн дор 1 олон улсын видео, 1 дотоодын контент, 1 GIF видео контентийг боловсруулан цахим орчинд түгээж 7000 гаруй хүнд хүрэв.

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛ

Байгууллагын гишүүд дэмжигчдийн хүрээнд:


Монголын Эмнести Интернэшнлийн 7000 гаруй гишүүд дэмжигчид хэдийгээр өнгөрсөн жил Ковид 19 цар тахлын хөл хориотой биечлэн уулзах нөхцөл боломж багатай жил байсан ч үйл ажиллагаанд цахимаар оролцож, орон нутгийн бүлэг, гишүүд идэвхжсэн байна.

Гишүүд, дэмжигчдийн оролцоо



Гишүүд дэмжигчдийн хүрээнд 2020 онд доорх үйл ажиллагаануудыг зохион байгуулсан байна:

- Шинэ гишүүний сургалт 6 удаа зохион байгуулж хүний эрх гэж юу болох хүний эрхийн үндсэн ойлголт, боловсролыг олгосон байна.
- Байгууллагын кампанит ажлын хүрээнд зохион байгуулагдсан үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэх, орон нутагт үйл ажиллагаа зохион байгуулахад чиглүүлэх уулзалт болон бусад багш, үйлдвэрчний эвлэлийн бүлгийн уулзалтыг зохион байгуулсан байна.
- Бүлэг, гишүүдийн дунд Ковид ба Хүний эрх, нүүрээр таних технологи, эмэгтэйчүүд ба хүүхдийн эрх, Үндсэн хууль ба Хүний эрх, Эмнестигийн стратеги зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлгүүд цахим болон цахим бусаар зохион байгуулагдсан.
- Гишүүд дэмжигчдийн хүрээнд хувь хүний хөгжил, манлайлал, ур чадварын сургалтууд зохион байгуулсан.
- Бүх гишүүдийн улирлын уулзалт цахим болон цахим бусаар улирал бүр зохион байгуулагдаж, гишүүд, дэмжигчид кампанит ажлыг хүрээнд активизм өрнүүлэх, хоорондоо танилцаж туршлага хуваалцах зэргээр цагийг үр бүтээлмжтэй өнгөрүүлсэн байна.



© Бүх гишүүдийн 4 дүгээр улирлын уулзалт

Орон нутгийн бүлэг

Мөн 2020 онд Завхан аймаг, Архангай аймагт Эрх зүйн хөтчийн сургалт хийх томилолтын үеэр бүлгийн үйл ажиллагаа явуулах, "ОББЭ" эрх зүйн хөтчийн ажлын байрыг түрээслэх, үйл ажиллагаа явуулахад бэлтгэхэд зориулсан тохижилт, тоног төхөөрөмжөөр хангах, шаардлагатай түрээс, харилцаа холбооны гэрээ зэрэг ложистик ажлууд хийгдсэн ба тус 2 орон нутгийн бүлэг идэвхжиж, үйл ажиллагаан дахь оролцоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



© Архангай аймаг



© Завхан аймаг

Сайн дурын ажилтан:

2020 онд нийт бүртгэлтэй 25 сайн дурын ажилтан МЭИ-ийн үйл ажиллагаанд өөрсдийн хүсэл санаачлагаар сайн дурын ажил хийсэн ба сайн дурын ажилтны бүртгэл хийгээгүй боловч үйл ажиллагаанд оролцох, Эмнестигийн зүгээс зохион байгуулсан өдөрлөг, тэмцээн уралдааны зохион байгуулалтын багт нэгдэж өөрсдийн цаг завыг зориулсан МЭИ-ийн гишүүд дэмжигчид мөн нэлээдгүй байсан. 2020 оны байдлаар нийт бүртгэгдсэн 823.43 цагийн сайн дурын ажил хийгдсэн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2020 оны санхүүгийн хураангуй тайлан

САЛБАР: МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ОРЛОГО 2020		2020 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31	2020 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31
		Төсөв (ам. доллар)	Гүйцэтгэл (ам. доллар)
Гишүүдийн татвар, хандивын тогтмол төлөлт		3,750.00	660.61
Тогтмол бус хандив		4,000.00	1,036.33
Тэтгэлэг олгогчийн санхүүжилт		22,970.00	8,462.63
Бусад сан арвижуулалтын орлого		18,360.00	10,751.11
Гаднаас олсон нийт орлогын дүн		49,080.00	20,910.68
ОУТөвийн санхүүжилт		166,628.00	168,051.00
НИЙТ САНХҮҮЖИЛТ		215,708.00	188,961.68
ЗАРЛАГА 2020			
Хүний эрхийн стратегийн зорилт	Зорилго 1 - 4	121,653.80	81,600.76
Өсөлтийн стратегийн зорилт	Зорилго 5 - Сан арвижуулах	9,895.00	2,636.83
Зорилго 5	Зорилго 5- Бусад асуудал	26,821.94	26,041.70
Стратегийн зорилгоос гаднах хүний эрхийн үйл ажиллагаа		9,561.61	7,575.43
Удирдлага, дотоод ардчилал болон бусад дэмжих ажиллагааны зардал		47,775.64	46,348.66
НИЙТ ЗАРДАЛ		215,708.00	164,203.39
Эхний үлдэгдэл			
Бэлэн мөнгө [касс ба банк]		78,629.43	
Нөөц сан		42,548.62	
Урьдчилж төлсөн төлбөр		75.74	
Авлага		4,561.64	
Өглөг		7,998.55	
Эцсийн үлдэгдэл			
Бэлэн мөнгө [касс ба банк]			55,520.79
Нөөц сан			85,474.74
Урьдчилж төлсөн төлбөр			5,882.99
Авлага			4,151.61
Өглөг			8,454.96

Хянасан гүйцэтгэх захирал:

Б. Алтантүвшин

Тайланг боловсруулсан ня-бо:

Т. Ариунаа





Аудит хийсэн Аудитор:

О. Чулуунбаатар /Эс-Эм Аудит ХХК/





2020 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ



ГЭРЭЭСЭЭ

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛЦГААЯ

